



**ДОРНОГОВЬ АЙМАГ
МАНДАХ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 04 сарын 20 өдөр

Дугаар 4/82

Төхөм

**Газрын дуудлага худалдааг
хойшлуулах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.23 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Иргэний хуулийн 197 дугаар зүйлийн 197.14 дэх даалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам", Засгийн газрын 2026 оны 45 дугаар тогтоол, Мандах сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 07/10 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мандах суманд 2026 оны 05 дугаар сарын 07-ны өдөр зохион байгуулагдахаар товлогдсон 7 байршил дахь газрын дуудлага худалдааг тухайн өдрийн газрын биржийн цахим системийн явцад үүсч болзошгүй ачаалал, түүнээс үүдэн гарах эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор хойшлуулсугай.

2. Дуудлага худалдаагаар эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалт, хугацаа, дуудлага худалдааны анхны үнэ, дэнчингийн хэмжээ, зохион байгуулах хэлбэр, хугацааг хавсралтаар баталсугай.

3. Газрын дуудлага худалдааны шинэ товыг олон нийтэд шуурхай мэдээлэхийг сумын газрын даамлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Н.Оюунгэрэл/-д үүрэг болгосугай.

4. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (Б.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ШИЖИР

54300

Сумын Засаг даргын 2026 оны 01 дугаар сарын
 -ны өдрийн 01 дугаар захирамжийн хавсралт

**ДУУДЛАГА ХУДАЛДААГААР ЭЗЭМШҮҮЛЭХ, АШИГЛУУЛАХ ГАЗРЫН БАЙРШИЛ, ХЭМЖЭЭ, ЗОРИУЛАЛТ, ХУГАЦАА,
 ДУУДЛАГА ХУДАЛДААНЫ АНХНЫ ҮНЭ, ДЭНЧИНГИЙН ХЭМЖЭЭ, ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛБЭР, ХУГАЦАА**

| № | Газрын байршил | Төлөвлөлтийн нэгж талбарын дугаар | Зориулалт | Талбайн хэмжээ /м2/ | Дуудлага худалдааны анхны үнэ /төг/ | Дэнчингийн хэмжээ /төг/ | Зохион байгуулах | |
|------------|---------------------------------|-----------------------------------|--|---------------------|-------------------------------------|-------------------------|------------------|------------|
| | | | | | | | Хэлбэр | огноо |
| 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| 1 | Шарга дэл | 4865811 | 2111: Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор | 1502 | 901,200 | 90,120 | Цахим | 2026.06.11 |
| 2 | Номгон ертөөнөөс баруун урагшаа | 4944291 | 2127: Терминал (ачиж, буулгах талбай) | 100000 | 60,000,000 | 6,000,000 | Цахим | 2026.06.11 |
| 3 | Нарангийн хоолой | 4944295 | 3412: Ус хангамжийн барилга, байгууламж | 60516 | 36,309,600 | 3,630,960 | Цахим | 2026.06.11 |
| 4 | Нарангийн хоолой | 4944296 | 3412: Ус хангамжийн барилга, байгууламж | 2669 | 1,601,400 | 160,140 | Цахим | 2026.06.11 |
| 5 | Нарангийн хоолой | 4944297 | 3412: Ус хангамжийн барилга, байгууламж | 521413 | 312,847,800 | 31,284,780 | Цахим | 2026.06.11 |
| 6 | Борхошуун төмөр замын хойд талд | 4944301 | 2127: Терминал (ачиж, буулгах талбай) | 992115 | 595,269,000 | 59,526,900 | Цахим | 2026.06.11 |
| 7 | Онгоны гудамж | 4949798 | 2111: Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор | 400 | 240,000 | 24,000 | Цахим | 2026.06.11 |
| Дүн | | | | 1678615 | 1,007,169,000 | 100,716,900 | | |